



ДУНДГОВЬ АЙМАГ  
АДААЦАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 18 өдөр

Дугаар 11/14

Тавин

Хорио цээрийн дэглэм тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.12 дахь заалт, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2 дахь заалт, Аймгийн Засаг даргын 2023 оны А/29 дүгээр захирамж, Улсын мал эмнэлгийн ариун цэврийн төв лабораторийн 23-1313 бүртгэлийн дугаартай шинжилгээний дүнгийн хуудсыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Адаацаг сумын Сүм багийн нутаг Хадан хошуу гэдэг газар гарсан мал амьтны гоц халдварт Бог малын мялзан өвчний шинж тэмдэг лабораторийн шинжилгээгээр батлагдсан тул хязгаарлалтын дэглэмийг цуцалж 2023 оны 01 сарын 18-ны өдрөөс хорио цээрийн дэглэм тогтоосугай.

2. Малын гоц халдварт бог малын мялзан өвчин нэмэгдсэнтэй холбогдуулан сумын хэмжээнд отор нүүдэл, шилжилт хөдөлгөөн хийхийг 2023 оны 03 сарын 01-ны өдрийн хугацаагаар хориглосугай.

3. Малын гоц халдварт өвчинтэй тэмцэх хариу арга хэмжээг мэргэжлийн арга зүйгээр хангаж үр дүнтэй зохион байгуулахыг Мал эмнэлгийн тасгийн малын эмч (А.Цолмонбаатар), Багийн засаг дарга, мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн малын эмч нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ч.УРАНЧИМЭГ